



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/УЧ

Улаанбаатар хот

Үндэсний Их баярын өдрүүдэд
хариуцлагатай жижүүрээр
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6, 109 дүгээр зүйлийн 109.4, Нийслэлийн Засаг даргын 2018 оны "Хариуцлагатай жижүүрийн ажиллах журам батлах тухай" А/998 захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тулгар төр байгуулагдсаны түүхт 2,230, 2,231 жилийн, Их Монгол Улс байгуулагдсаны 815, 816 жилийн, Тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, 111 жилийн, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн давхацсан Үндэсний баярын өдрүүдэд байгууллагын хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэх албан хаагчдын нэрс, ажиллах хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хариуцлагатай жижүүрээр ажиллах албан хаагчдад холбогдох журам, мөрдүүлэх чиглэлээр гарсан бодлого, шийдвэр, заавар зааварчилгааны хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагыг шуурхай мэдээллээр ханган ажиллахыг үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж хариуцлагатай жижүүрээр ажиллах албан хаагчдыг нэгдсэн удирдлагаар ханган, ажилласан мэдээ, тайланг нэгтгэж, танилцуулахыг Хүний нөөц, ёс зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн (Б.Энхцэцэг)-т даалгасугай.

ДАРГА *D. Balm* Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2022 оны 07 сарын
05-ний өдрийн 11 дугаар
тушаалын хавсралт

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ӨДРҮҮДЭД ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРЭЭР
АЖИЛЛАХ АЛБАН ХААГЧДЫН НЭРС, ХУВААРЬ

Д/д	Албан тушаалтын овог, нэр	Албан тушаал	Жижүүрээр ажиллах огноо	Цаг
1	Л.Оюунхорлоо	Архив бичиг хэргийн эрхлэгч	2022.07.11	08:00-17:00
2	Б.Энхцэцэг	Хүний нөөц, ёс зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	2022.07.12	08:00-17:00
3	Э.Мөнхзул	Бодлогын баримт бичиг, тайлан, сургалт хариуцсан ахлах	2022.07.13	08:00-17:00
4	Б.Энхцэцэг	Хүний нөөц, ёс зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	2022.07.14	08:00-17:00
5	М.Мөнхцацрал	Мэдээллийн төвийн ажилтан	2022.07.15	08:00-17:00